# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 27 өдөр Дугаар 674 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 6 нэрийн, нийт 11,727,950.00 (арван нэгэн сая долоон зуун хорин долоон мянга есөн зуун тавин) төгрөгийн балансын үнэ, 6,714,572.81 (зургаан сая долоон зуун арван дөрвөн мянга таван зуун далан хоёр төгрөг наян нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Хил хамгаалах ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Х.Лхагвасүрэн болон тогтоолд заасан байгууллагуудын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

31-Khuraldaan 13000/003

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн
674 дугаар тогтоолын хавсралт

## ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨНД БҮРТГЭЛТЭЙ, БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Үндсэн хөрөнгийн нэр, марк | Хэмжих нэгж | Ашиглалтанд орсон огноо | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ (төгрөг) | Нийт үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэгдэл өртөг (төгрөг) | Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг) | | | Шилжүүлэх хуулийн этгээдийн нэр | Шилжүүлэн авах хуулийн этгээдийн нэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Нэг бүрийн үнэ (төгрөг) | Нийт үнэ (төгрөг) | Цаашид ашиглах жил (хугацаа) | | |
| 1.Тавилга, эд хогшил | | | | | | | | | | | | | |
| 1 | Сандал /хар, 4хөлтэй/ | ш | 2019.11.08 | 54 | 100,000.00 | 5,400,000.00 | 1,574,999.10 | 3,825,000.90 | | | | Хууль зүй, дотоод хэргийн яам | Хил хамгаалах ерөнхий газар |
| 2 | Сандал /эвхдэг, цагаан, 313/ | ш | 2015.11.01 | 5 | 235,400.00 | 1,177,000.00 | 843,516.25 | 333,483.75 | | | | | |
| 3 | Бичгийн ширээ /2014/ | ш | 2014.06.24 | 1 | 741,950.00 | 741,950.00 | 630,657.58 | 111,292.42 | | | | | |
| Дүн | | | | | | 7,318,950.00 | 3,049,172.93 | 4,269,777.07 | | | | | |
| 2.Тоног төхөөрөмж | | | | | | | | | | | | | |
| 4 | Хөргүүр /120 t/ | ш | 2016.08.17 | 1 | 1,350,000.00 | 1,350,000.00 | 1,350,000.00 | - | 500,000.00 | 500,000.00 | 3 | Хууль зүй, дотоод хэргийн яам | Хил хамгаалах ерөнхий газар |
| 5 | Шарах шүүгээ /хаалгатай,612/ | ш | 2019.12.17 | 1 | 1,859,000.00 | 1,859,000.00 | 1,115,399.88 | 743,600.12 | | | | | |
| 6 | Хүчилтөрөгчийн аппарат | ш | | 1 | 1,200,000.00 | 1,200,000.00 | 1,200,000.00 | - | 500,000.00 | 500,000.00 | 3 | | |
| Дүн | | | | | | 4,409,000.00 | 3,665,399.88 | 743,600.12 | | | | | |
| Нийт дүн | | | | 63 | | 11,727,950.00 | 6,714,572.81 | 5,013,377.19 | | | | | |